

**“Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжилт бус хуралын тэмдэглэл**

2018.12.10

УБ хот Баянгол Ресторан
хурлын заал 10.30-11.30 цагт

2018 оны 12 сарын 10 -ны өдөр “Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжилт бус хурлаар “Хай Би Ойл” ХК –н ТУЗ –г шинээр сонгох асуудлыг хэлэлцэж батлав.

Хэлэлцсэн асуудал:

1. “Хай Би Ойл” ХК-ий ТУЗ шинээр томилох тухай.

Б. Мянганбаяр – Тооллогын комисс ирцээ танилцуулна уу.

- Д. Тогосбаатар танилцуулав.

Ирц: компаний нийт хувьцааны 47 494 123 ширхэг буюу 91,13%-н ирцтэй байгаа тул хурлыг эхлүүлж болно гэж үзэж байна.

Б. Мянганбаяр –

Хурлын ирц 91,13 хувьтай байгаа тул “Хай Би Ойл” ХК-ий хувьцаа эзэмшигчдийн ээлжилт бус хурал нээснийг мэдэгье.

Энд хүрэлцэн ирсэн та бүгдэд баярлалаа. Хурлын дэгийг танилцуулав.

- Бид манай томоохон хувьцаа эзэмшигч Firebird Mongol Holdings A S.A.R.L компаний ирүүлсэн хүсэлтээр “Хай Би Ойл” ХК-ий Төлөөлөн удирдах зөвлөлийг шинээр сонгох болсон. Энэ удаагийн шинээр сонгогдож байгаа 15 хүмүүс бол ТУЗ-н дэргэдэх нэр дэвшүүлэх хороогоор дэмжигдэж ирсэн тул сарын өмнөөс хуулийн хүрээнд хэвлэл мэдээлэл болон телевиз радиогоор хурлын товыг зарлуулж хувьцаа эзэмшигчдэд танилцуулах материал хүргүүлсэн болно.

- Хувьцаа эзэмшигч Ц. Ганзориг энд нэр дэвшиж байгаа хүмүүсээс биечлэн иирсэн хүмүүс байна уу.

Мянганбаяр – биечлэн ирсэн хүмүүс өөрсдийгөө танилцуулна уу / үүнд :Ө. Хүдрээ, Б. Лхагвадорж, Б. Мянганбаяр, Б. Батбаатар нар өөрсдийгөө танилцуулж/ бусад нэр дэвшигдсэн гишүүдийг хурлын дарга Б. Мянганбаяр танилцууллаа. Эдгээрээс тодруулж асуух зүйл байна уу асуулт байхгүй бол саналаа кумулятив аргаар хурааж тооллогын комисс дүн гартал хурлыг түр завсарлая.

Тооллогын комиссын дарга

Д. Тогосбаатар дүнгээ танилцуулав.

Үүнд: нийт ердийн гишүүдэд 9 хүн нэр дэвшснээс Б. Лхагвадорж 13,97%, Б. Мянганбаяр 16,06%, Б. Батбаатар 16,06%, А. Батбаяр 16,06%, С. Ариунбат 16,06%, Б. Мягмаржав нар 16,06%-гаар, Хараат бус гишүүдэд 6 хүн нэр дэвшсэнээс А. Харцага 25,75%, Т. Тамир 26,74%, Ц. Батбаяр 26,74%-гаар тус тус сонгогдов.

Б. Мянганбаяр ердийн гишүүдэд Б. Батбаатар, Б. Мянганбаяр, А. Батбаяр, Б. Лхагвадорж, С. Ариунбат, Б. Мягмаржав нарыг хараат бус гишүүдэд А. Харцага, Т. Тамир, Ц. Батбаяр нарыг тус тус батлав. Хурал хаасныг мэдэгдье. Баярллаа.

Хурлын дарга:

..... 

Б.Мянганбаяр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: :

..... 

Д. Хандаа

УБ хот Баянгол Ресторан хурлын заал 10.30-11.30 цагт



**“ХАЙ БИ ОЙЛ” ХК – ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г

Г

ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

“Хай Би Ойл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 12 сарын 10-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд олонхийн санал авсан:

Ердийн гишүүдэд:

1. Б.Мянганбаяр
2. Б.Батбаатар
3. Б.Мягмаржав
4. А.Батбаяр
5. С.Ариунбат
6. Б.Лхагвадорж

Хараат бус гишүүдэд:

7. А.Харцага
8. Т.Тамир
9. Ц.Батбаяр

нарыг тус тус Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгосугай.

2. Компанийн үр ашигтай ажиллагааг удирдан зохион байгуулахыг үүрэг болгосугай.


ХУРЛЫН ДАРГА *Б.Мянганбаяр* **Б.МЯНГАНБАЯР**